



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 23 (356)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай*
- *Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны зургаадугаар сарын 14 №23 (356)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

277.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай	536
278.	Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	540
279.	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	542
280.	Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай	543
281.	Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	546
282.	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай	546
283.	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	549
284.	Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай	549
285.	Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	549

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

286.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 30	550
287.	Хуулиудын төслийг буцаах тухай	Дугаар 31	550
288.	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай	Дугаар 32	550
289.	"Энхийн төлөө" медаль бий болгох тухай	Дугаар 33	550
290.	Үнэт цаасны хорооны гишүүнийг чөлөөлөх, томилох тухай	Дугаар 34	552

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

291.	Паавангийн Дамдинд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 87	552
292.	Нямын Ширнэндугарт Монгол Улсын гавъяат тээвэрчин цол хүртээх тухай	Дугаар 88	552
293.	Зарим багш нарт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай	Дугаар 89	553
294.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 90	553

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

295.	Засвар, заавар батлах тухай	Дугаар 88	557
------	-----------------------------	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Нийтлэг үндэслэл

5.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хохирогчийн зөрчигдсөн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

5.1.1. "гэр бүлийн хүчирхийлэл" гэж гэр бүлийн хүрээнд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхгүй;

2 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж

5.1.2. "болзошгүй хүчирхийлэл" гэж тухайн нөхцөл байдал нь гэр бүлийн хүчирхийлэлд хүргэхээр, эсхүл хүчирхийлэл дахин үйлдэгдэхээр байгаа;

2.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Эрүүгийн хууль³, Гэр бүлийн тухай⁴, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль⁵ энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

5.1.3. "хамгаалах байр" гэж гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл болзошгүй хүчирхийлэлд өртөх магадлалтай хохирогч, түүний бага насны хүүхдийг тодорхой хугацаагаар байрлуулж, хохирогчид үйлчилгээ үзүүлэх газрыг;

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

5.1.4. "хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт" гэж хүчирхийлэл үйлдэгчид гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцанаас үүссэн асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн зохих хөтөлбөрийн дагуу явуулах сургалтыг;

3 дугаар зүйл. Хуулийн зохицуулалтад хамаарах этгээд

5.1.5. "хохирогчид үзүүлэх үйлчилгээ" гэж хохирогчид хэрэгцээтэй мэдээлэл, эрх зүйн болон бусад зөвлөгөө өгөх, сэтгэхүй нь түр хямарсан үед эмчилгээ хийх, нөхөн сэргээх ажиллагааг;

3.1. Энэ хуулийн зохицуулалтад Гэр бүлийн тухай хуульд заасан гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн хамаарна.

3.2. Энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүмүүс, түүнчлэн Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлсний, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосны үр дүнд тухайн иргэний асрамжид байгаа этгээд нэгэн адил хамаарна.

5.1.6. "эрх хязгаарлах арга хэмжээ" гэж хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх албадлагыг.

4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зарчим

6 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр

4.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хууль дээдлэх, хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээг шуурхай авах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх зарчимд үндэслэнэ.

6.1. Энэ хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн хэлбэртэй байж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцогчдын эдлэх эрх, хүлээх үүрэг

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

² Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн

³ Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн

⁴ Гэр бүлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 8 дугаарт

⁵ Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 6 дугаарт нийтлэгдсэн

7 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи төрийн байгууллагын бүрэн эрх

7.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи бодлого, хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх;

7.1.2. энэ хуулийн 7.1.1-д заасан хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг улсын төсвийн төсөлд тусгаж, Улсын Их Хуралд оруулах.

7.2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.2.1. гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээг зохион байгуулах;

7.2.2. хамгаалах байранд тавигдах наад захын шаардлагыг тодорхойлох.

7.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.3.1. гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай⁶ хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд зохион байгуулах;

7.3.2. гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэх.

8 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрх

8.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. харьяа нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

8.1.2. гэр бүлийн хүчирхийлэлтэй

тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг мэдээ, судалгаанд үндэслэн өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэх;

8.1.3. хууль хамгаалах байгуул - лагуудтай хамтран ажиллаж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих;

8.1.4. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

9 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи цагдаагийн байгууллагын үүрэг

9.1. Цагдаагийн байгууллага нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох талаар дараахь үүрэг хүлээнэ:

9.1.1. гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол хүлээн авч, бүртгэх, хүчирхийлэл үйлдэгдсэн газар дээр хүрэлцэн очиж хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах;

9.1.2. энэ хуульд заасны дагуу хохирогчид түүний эдлэх эрх болон хүчирхийлэл үйлдэгчид эрхийг нь хязгаарлах арга хэмжээ авахуулахаар шийдвэр гаргуулах журмын талаар тайлбарлан өгөх;

9.1.3. хүчирхийлэл үйлдэгчид захиргааны болон эрүүгийн шийтгэл ногдуулж болох тухай сануулах;

9.1.4. шаардлагатай тохиолдолд хохирогчийг эмнэлэгт, эсхүл хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл, садангийн хүний нь түр хамгаалалтад өгөх;

9.1.5. шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэл үйлдэгчийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан саатуулах;

9.1.6. согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг хууль тогтоомжийн дагуу эрүүлжүүлэх байранд хүргэх;

9.1.7. хохирогчийг энэ хуулийн 5.1.5-д заасан үйлчилгээнд хамруулах талаар нийгмийн ажилтанд мэдэгдэх;

9.1.8. хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах;

9.1.9. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

⁶ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 1 дүгээрт нийтлэгдсэн



10 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи нийгмийн ажилтны үүрэг

10.1. Нийгмийн ажилтан нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

10.1.1. тухайн гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын талаар үнэлгээ өгөх, орчны сөрөг нөлөө, аюулын зэргийн түвшинг цагдаагийн ажилтантай хамтран тогтоох;

10.1.2. хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулж, энэ хуулийн 7.3.2-т заасан хөтөлбөрийн дагуу явуулах;

10.1.3. хохирогчид үзүүлэх гэр бүлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагын туслалцаатайгаар явуулах;

10.1.4. хохирогчид үзүүлсэн үйлчилгээний талаархи тайлан мэдээ гаргаж, гэр бүлийн хүчирхийллийн холбоотой мэдээллийн сүлжээ бий болгоход оролцох.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн бус байгууллагын оролцоо

11 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төрийн бус байгууллагын оролцоо

11.1. Хохирогчийг хамгаалах байраар хангах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах, хохирогчид үзүүлэх үйлчилгээ болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаархи бусад үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан журмын дагуу төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

11.2. Төрийн бус байгууллага нь энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааг дүрмийнхээ зорилгод нийцүүлэн явуулж болно.

12 дугаар зүйл. Итгэмжлэгдсэн төлөөлөгч

12.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага нь хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж болно.

12.2. Итгэмжлэгдсэн төлөөлөгч дараахь эрх эдэлнэ:

12.2.1. хохирогчийн эрх, хууль ёсны

ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, бусад этгээдтэй харилцах;

12.2.2. гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл олж авах, судалгаа явуулах;

12.2.3. гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаархи саналаа эрх бүхий байгууллагад оруулах.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээлэл өгөх, хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээ

13 дугаар зүйл. Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээлэл

13.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, эмнэлгийн мэргэжилтэн албан үүргээ биелүүлж байх үедээ гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа нь илэрхий болсон тохиолдолд цагдаагийн байгууллага, боломжгүй бол нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

13.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй байгаа тухай цагдаагийн буюу нутгийн захиргааны байгууллагад мэдээлж болно.

13.3. Энэ хуулийн 13.1, 13.2-т заасан этгээд мэдээллээ цахилгаан холбоо, шуудан, мэдээллийн хэрэгслийг ашиглан өгч болно.

13.4. Гэр бүлийн хүчирхийллийн тухай мэдээллийг хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн байнга буюу түр оршин сууж байгаа, эсхүл хүчирхийлэл үйлдэгдсэн газрын, хэрэв хохирогч нь эрүүл мэндийн байгууллага, хамгаалах байранд болон хүчирхийлэл үйлдэгч нь энэ хуулийн 5.1.4-т заасан албадан сургалт явуулдаг байгууллагад байгаа бол уг байгууллагын оршин байгаа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хүлээн авч, энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан арга хэмжээ авна.

14 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох талаархи сум, багийн Засаг даргын үүрэг

14.1. Тухайн харьяалах нутаг дэвсгэртээ сум, багийн Засаг дарга гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, болзошгүй хүчирхийлээс урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

14.1.1. хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүчирхийлэл үйлдэгчийг захиргааны байранд дуудан ирүүлж, шаардлага тавих;

14.1.2. шаардлагатай гэж үзвэл хохирогчийн байгаа гэр, орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, эсхүл боломжтой

бол хохирогчийг төрөл, садангийн хүний нь төр хамгаалалтад өгөх;

14.1.3.гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн тухай хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах.

15 дугаар зүйл. Хохирогчийг хамгаалах арга, түүний нууцыг задруулахгүй байх талаар бусад этгээдийн хүлээх үүрэг

15.1. Хохирогчийг хамгаалах зорилгоор дараахь аргыг хэрэглэж болно:

15.1.1. хамгаалах байранд хүргэх;

15.1.2. эцэг, эх, төрөл, садны хүн, эсхүл хамт олны нь түр хамгаалалтад өгөх;

15.1.3. шаардлагатай гэж үзвэл хүүхэд асран хүмүүжүүлэх, эсхүл нийгмийн халамжийн байгууллагад шилжүүлэх;

15.1.4. энэ хуулийн 5.1.5-д заасан үйлчилгээнд хамруулах.

15.2. Хохирогч нь эрх зүйн асуудлаар хууль зүйн туслалцаа авах, хүчирхийлэл үйлдэгчээс гэрлэлтээ цуцлуулах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, тэжээн тэтгүүлэх, эсхүл хууль тогтоомжийн дагуу эдийн болон эдийн бус гэм хорыг арилгуулахаар нэхэмжлэл гаргах эрхтэй.

15.3. Нийгмийн ажилтан болон энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан этгээд зөвлөгөө өгөх явцдаа итгэмжлэлээр олж мэдсэн зүйлээ бусдад задруулахыг хориглоно.

15.4. Ажил үүргээ гүйцэтгэж байсантай холбоотой эсэхээс үл хамааран хамгаалах байрны байршлын талаар мэдсэн этгээд энэ тухай бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

16 дугаар зүйл. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ

16.1. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах зорилгоор дараахь арга хэмжээ авч болно:

16.1.1. тусдаа амьдрахыг даалгах;

16.1.2. хамгаалах байранд, эсхүл энэ хуулийн 15.1.3-т заасны дагуу өөр газарт байгаа хохирогчтой уулзах болон уулзахаар оролдохыг хориглох;

16.1.3. хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг хориглох;

16.1.4. асрамжиндаа байгаа насанд

хүрээгүй хүнтэй харилцахыг түр хориглох;

16.1.5. зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах;

16.1.6. шаардлагатай гэж үзвэл согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан эмчилгээ хийлгэх, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх.

16.2. Энэ хуулийн 16.1-д заасан арга хэмжээ авагдсан этгээд хохирогчийг хуулийн дагуу асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээсээ чөлөөлөгдөхгүй.

17 дугаар зүйл. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шүүхийн шийдвэр

17.1. Хохирогчийн гомдол, цагдаагийн байгууллагын ажилтны, эсхүл өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хүсэлт, түүнд хавсаргасан нотлох баримтыг үндэслэн хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авах тухай шийдвэрийг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай¹ хуулийн 82.1.8-д заасны дагуу гаргана.

17.2. Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор шүүх нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн тухай гомдол хүлээн авснаас хойш 24 цагийн дотор энэ хуулийн 16.1.1-16.1.5-д заасан арга хэмжээ авах тухай шийдвэр гаргаж болно.

17.3. Энэ хуулийн 16.1-д заасан хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ тухай нөхцөл байдалд нь тохируулж нэг жил хүртэл хугацаагаар авч болно.

17.4. Талууд энэ хуулийн 17.1-д заасан шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхтэй. Ийнхүү гомдол гаргасан явдал тухайн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг зогсоох үндэслэл болохгүй.

17.5. Энэ хуулийн 17.1-д заасан шийдвэр нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн талаар захиргааны зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулах, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэн шалгах болон иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

17.6. Шүүх энэ хуулийн 17.1-д заасны дагуу шийдвэрээ гаргахдаа дараахь нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

17.6.1. хохирогчтой удаа дараа хэрцгий хандсан, заналхийлсэн, хүч хэрэглэсэн;

17.6.2. хүчээр бэлгийн харьцаанд оруулсан буюу оруулахыг завдсан;

17.6.3. хохирогчийг төрөл садан,

¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн



хамт олноос нь тусгаарлаж, сэтгэл санааны хүнд дарамтад оруулсан;

17.6.4.тэжээн тэтгэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн буюу хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учруулж байсан;

17.6.5.согтууруулах ундаа мансууруулах бодис байнга буюу удаа дараа хэрэглэж хохирогчийг айдас, түгшүүрт байдалд оруулсан;

17.1.6.гэр бүлийн хүчирхийллийн улмаас энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээдийн хэн нэгний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учирч болзошгүй байгаа.

18 дугаар зүйл. Хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах журам

18.1. Шүүхийн шийдвэрт энэ хуулийн 16.1.2, 16.1.4-т заасан арга хэмжээ тусгагдаагүй бөгөөд уг шийдвэр хүчинтэй байх хугацаанд хохирогч өөрөө буюу насанд хүрээгүй болон иргэний эрх зүйн чадамжгүй хохирогчийн хувьд асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан бол нийгмийн ажилтны зөвшөөрлөөр хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулж болно.

18.2. Шүүхийн шийдвэрт энэ хуулийн 16.1.2, 16.1.4-т заасан арга хэмжээ тусгагдсан бөгөөд зайлшгүй шаардлагаар насанд хүрээгүй этгээдийг

хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах бол нийгмийн ажилтны зөвшөөрлөөр итгэмжлэгдсэн төлөөлөгчийг байлцуулан уулзуулж болно.

18.3. Энэ хуулийн 18.1, 18.2-т заасан уулзалтыг цагдаагийн эрх бүхий ажилтан зохион байгуулж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

19 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрсөн этгээдэд түүний үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанар, зөрчлийн байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

20 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

20.1. Энэ хуулийг 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуульд дор дурдсан агуулга бүхий зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/2¹ дугаар зүйл:

"2¹ дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1¹ "даатгуулагч" гэж хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг;

2¹ "нийгмийн даатгалын байгууллага" гэж ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох үйл ажиллагааг эрхэлж байгаа хуулийн этгээдийг;

3¹ "нийгмийн даатгалын сан" гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж,

төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг;

4¹ "нийгмийн даатгалын шимтгэл" гэж нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор даатгуулагч болон ажил олгогчоос хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын санд төлөх урьдчилсан төлбөрийг;

5¹ "нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа" гэж ажил олгогч болон даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг даатгалын санд шилжүүлсэн өдрийг;

6¹ "тэтгэврийн төрлийг сонгох эрх" гэж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан болзлын дагуу хоёр буюу түүнээс дээш төрлийн тэтгэврийн эрх нэгэн зэрэг үүсч байгаа даатгуулагч тэтгэврийн төрлийг сонгож, тэтгэвэр тогтоолгон авах эрхийг;

7¹ "шимтгэл төлөгч" гэж хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэг хүлээсэн хуулийн этгээдийг;

8/“тэтгэвэр” гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, тахир дутуу болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд /хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл/-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг;

9/“тэтгэмж” гэж хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг;

10/“төлбөр” гэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 30 буюу түүнээс дээш хувиар алдсан даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нөхөн олгох хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез, ортопед/-ний үнэ, рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын газрын үйлчилгээний хувьсах зардлыг;

11/рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчний сувиллын газрын үйлчилгээний хувьсах зардал” гэж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагч сувиллын газар эмчлүүлэхэд гарсан зардлыг нөхөх зорилгоор үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох төлбөрийг.”

2/ 26' дугаар зүйл:

“26' дугаар зүйл. Нийгмийн даатгалын байцаагчийн нийгмийн баталгаа, мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл

1.Нийгмийн даатгалын байцаагч албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон, бусдын нөлөөгөөр амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний ар гэрт дараахь буцалтгүй тусламжийг олгоно:

1/хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд эмнэлгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, албан тушаалын үндсэн цалингийн зөрүү;

2/тахир дутуу болсон тохиолдолд тахир дутуугийн тэтгэвэр, албан тушаалын үндсэн цалингийн зөрүү;

3/амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь хохирогчийн 3 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж.

2.Энэ хуулийн 26'.1.3-т заасан буцалтгүй тусламжийг ажиллаж байсан байгууллага олгож, хуульд заасны дагуу гэм буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлнэ.

3.Нийгмийн даатгалын байцаагч мэргэшлийн зэрэгтэй байна. Мэргэшлийн зэргийг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар тогтооно.

4.Нийгмийн даатгалын байцаагчид ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгож болно. Нийгмийн даатгалын байцаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар тогтооно.

5.Нийгмийн даатгалын байцаагч нь үйлчилгээний онцлогт тохирсон ажлын тусгай хувцсыг үнэ төлбөргүй хэрэглэнэ. Нийгмийн даатгалын байцаагчийн ажлын тусгай хувцас, ялгах тэмдгийн загвар, хэрэглэх журам, эдэлгээний хугацааг нийгмийн даатгалын төв байгууллага батална.”

3/ 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 5, 6 дахь заалт:

“4/энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийн заалтыг зөрчсөн, даатгуулагчид нийгмийн даатгалын дэвтэр нээж баталгаажуулаагүй, уг зөрчлийн улмаас даатгуулагчийн эрх ашгийг хохироосон албан тушаалтыг 10000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна;

5/нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, ашигласан бол хууль бус олсон орлого, эд зүйлсийг хурааж, албан тушаалтыг 5000-50000, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна;

6/даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацаа болон хөдөлмөрийн нөхцөлийг буруу тогтоосон албан тушаалтыг 10000-50000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.”

4/26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7, 8, 9 дэх заалт:

“7/байгууллага, аж ахуйн нэгжийн ажлын байр, ажиллагчдын тоог цалингийн сан, төлсөн шимтгэлийн тооцоотой тулган шалгах;

8/ажиллагчдын тоог дарагдуулсан, хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй ажиллуулсан, хөдөлмөрийн хөлслий доод хэмжээнээс доогуур цалин олгож байсан болон нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүйгээс өр үүсгэсэн, ажиллагчдын төлсөн шимтгэлийг нийгмийн даатгалын санд хугацаанд нь оруулаагүй зэрэг зөрчил гаргасан албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх, шаардлагатай бол хуулийн байгууллагад асуудал тавьж шийдвэрлүүлэх;

9/нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг удаа дараа зөрчсөн байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх.”

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ шалтгааны улмаас даатгуулагчид учирсан хохирлыг ажил олгогч хариуцна.” гэсэн хоёр дахь өгүүлбэр, 4



дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "иргэн" гэсний дараа "хувиараа хөдөлмөр эрхлэх замаар" гэж, 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "хээл хохууль авах," гэсний дараа "ёс зүйн хэм хэмжээ зөрчих, мэдээллийн нууц задруулах," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 31 дүгээр зүйл, 7 дугаар зүйлийн хоёр дахь өгүүлбэр, 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ "31 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэх

1.Нийгмийн даатгалын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг нийгмийн даатгалын сангийн орлогоос санхүүжүүлнэ.

2.Нийгмийн даатгалын сангийн орлогоос санхүүжүүлэх нийгмийн даатгалын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлын төсвийг санхүү, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл жил бүр батална."

2/ 7 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэр:

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд дор дурдсан агуулга бүхий хэсэг, заалт нэмсүгэй:

1/17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээг нийгмийн хамгаалал, болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно"

2/ 4 дүгээр зүйлийн 5, 6 дахь заалт:

"5/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл;

6/үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын даатгуулагчийг сувилахад ногдох тусламж үйлчилгээний хувьсах зардал"

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас

"Хэрэв давхардахаар байвал даатгуулагч илүү таатай нөхцөлтэй тэтгэвэр буюу тэтгэмжийг зөвхөн нэг удаа сонгон авах эрхтэй"

3/ 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

"4/тогтоосон хугацаанд төлөөгүй шимтгэл болон нөхөн ногдуулсан шимтгэл, алданги, хүү, торгуулийг шимтгэл төлөгчөөс үл маргах журмаар гаргуулах;"

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "25000-50000 төгрөгөөр" гэснийг "иргэнийг 5000-30000, албан тушаалтныг 30000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-250000 төгрөгөөр" гэж, 26 дугаар зүйлийн 1дэх хэсгийн "3-аас доошгүй" гэснийг "2-оос доошгүй" гэж, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "4" дэх заалтын дугаарыг "7" гэж, хуульд "рашаан сувилал" гэснийг "рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувилал" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР

олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийн жагсаалтыг эрүүл мэнд болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална" гэсэн агуулга бүхий 2 дахь өгүүлбэр, мөн хэсгийн "үнийг" гэсний дараа "Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийг баримтлан" гэж, 16 дугаар зүйлд "хийлгээ" гэсний дараа "тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх" гэж, 17 дугаар зүйлийн 3 дах хэсгийн "сувиуулбал" гэсний дараа "рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувилалд ирэх, очих унааны зардлыг" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

"1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир, дутуу болж Монгол Улсад хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез, ортопеди/ хийлгэсэн бол үнийг эхний удаа 100 хувь, цаашид нийгмийн даатгалын шимтгэл үргэлжлүүлэн төлж байгаа бол протез, ортопедийн эдэлгээний хугацаа дууссан тохиолдол бүрт үнийг бүрэн, нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй бол хоёр дахь удаад үнийн 50

хувийг нийгмийн даатгалын байгууллага тус тус нөхөн төлнө."

4 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн "олгоно" гэснийг "болон хуульд заасан бусад зэрдлэг санхүүжүүлэнэ"

гэж, мөн хуулийн "рашаан сувилал" гэснийг "рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувилал" гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.ТӨМӨР-ОЧИР

**2004 оны 5 дугаар
сарын 13-ны өдөр**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**Улаанбаатар
хот**

**ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДОЛЫН ВИРУСЫН ХАЛДВАР,
ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛООС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх талаарх төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтний үүрэг, иргэд, уг вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүний эрх, үүргийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль тогтоомж

2.1. Хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмолын хомсдолоос сэргийлэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "хүний дархлал хомсдолын вирус" гэж зөвхөн хүний биеийн дархлалын эсүүдийг гэмтээдэг вирус /ретровирус-ыг;

3.1.2. "дархлалын олдмол хомсдол" гэж хүний биеийн дархлалын эсүүд гэмтэж, дархлалын тогтолцоо алдагдсанаар эмгэг, хам шинжүүд илрэхийг;

3.1.3. "хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх" гэж хүн амд хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол

тархахад нөлөөлж буй нөхцөл, шалтгааныг арилгах, тархалтыг бууруулах, халдвар дамжих замыг таслан зогсооход чиглэсэн цогц арга хэмжээг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх талаарх төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

4 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх

4.1. Засгийн газар хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж, хяналт тавих;

4.1.2. хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх талаар төрийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

4.1.3. хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүмүүс эрхэлж болохгүй ажил, үйлчилгээг тогтоох.

5 дугаар зүйл. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

5.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх асуудлыг боловсруулах, энэ талаар гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.1.2. хүний дархлал хомсдолын

вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолтой холбогдсон албан ёсны мэдээ, мэдээллийг хариуцах;

5.1.3. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг бусад халдаахгүй байх талаар уг вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүн болон түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөгөө, зааварчилгаа өгөх журмыг батлах.

6 дугаар зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх

6.1. Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх, энэ талаархи сургалт, сурталчилгааны ажилд иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг оролцуулах, уг вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авна.

6.2. Бүх шатны Засаг дарга хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль тогтоомжийн биелэлтийг өөрийн нутаг дэвсгэрт зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

7 дугаар зүйл. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

7.1. Эрүүл мэндийн байгууллага хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх талаар дараахь үүрэгтэй:

7.1.1. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг илрүүлэх, магадлах, уг вирусын халдвар авсан болон дархлалын олдмол хомсдолтой хүмүүсийг эмчлэх арга хэмжээ авах;

7.1.2. хариуцсан нутаг дэвсгэртээ оршин суугаа бөгөөд хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүн уг вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг бусад халдаахгүй байх талаар түүнд болон түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөгөө, зааварчилгаа өгөх ажлыг зохион байгуулах;

7.1.3. зүү, тариур болон эмнэлгийн бусад багаж хэрэгслээр хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол тархахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх;

7.1.4. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг илрүүлэх шинжилгээ хийж баталгаажуулах үүс, цусан бүтээгдэхүүн, донорын эд эрхтнийг эмчилгээний зориулалтаар хэрэглэхгүй байх.

7.2. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүн өөртөө хяналт тавих чадваргүйгээс энэ хуульд заасан үүргээ биелүүлж чадахгүй болсон тохиолдолд түүнийг тусгаарлаж эмчилнэ.

7.3. Энэ зүйлийн заалт өмчийн аль ч хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагад нэгэн адил үйлчилнэ.

8 дугаар зүйл. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн-ний үүрэг

8.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн хүн амыг хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх талаар дараахь үүрэгтэй:

8.1.1. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг илрүүлсэн, оношилсон тухайгаа харьяалах эрүүл мэндийн байгууллагад зохих журмын дагуу заавал мэдээлэх;

8.1.2. хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүн биеэ хэрхэн авч явах, уг вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг бусад халдаахгүй байх талаар түүнд болон түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид зөвлөгөө, зааварчилгаа өгөх;

8.1.3. хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүнд эмнэлгийн зайлшгүй тусламж үзүүлэхээс татгалзахгүй байх.

8.2. Энэ хуулийн 7.1.3-д заасан үүрэг эмч, эмнэлгийн мэргэжилтэнд нэгэн адил хамаарна.

9 дүгээр зүйл. Иргэний эрх, үүрэг

9.1. Монгол Улсын иргэн дараахь эрхтэй:

9.1.1. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг илрүүлэх үзлэг, шинжилгээ, халдвар судлалын хяналт хийж байгаа этгээдээс уг үзлэг, шинжилгээ, хяналтыг хийх эрхтэй болохыг нь нотлох албан ёсны баримт бичгийг шаардах;

9.1.2. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолыг илрүүлэх, магадлах эмнэлгийн үзлэг, шинжилгээнд сайн дураар хамрагдах;

9.1.3. хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдолын талаар үнэн зөв, бодит мэдээлэл олж авах, хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос урьдчилан сэргийлэх аргад суралцах.

9.2. Монгол Улсын иргэн дараахь үүрэгтэй:

9.2.1. хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос

сэргийлэх, тэмцэх талаар төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, эрүүл мэндийн болон холбогдох бусад байгууллагаас зохион байгуулж байгаа арга хэмжээнд оролцох;

9.2.2. хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүмүүсийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчихгүй байх.

9.3. Энэ зүйлийн заалт тус улсын нутаг дэвсгэрт иргэн суугаа болон дамжин өнгөрөгч гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна.

10 дугаар зүйл. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан болон дархлалын олдмол хомсдолтой хүний эрхийг хамгаалах

10.1. Хуульд өөрөөр заагаагүй бол хүний дархлалын олдмол хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон хүний эрх, эрх чөлөөг хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой гэсэн үндэслэлээр хязгаарлахыг хориглоно.

10.2. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүнийг гутаан доромжлох, ялгаварлан гадурхах бүх хэлбэрийг хориглоно.

10.3. Албан тушаалтан, иргэн хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүмүүсийн талаарх мэдээллийг задруулахыг хориглоно.

11 дүгээр зүйл. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүний үүрэг

11.1. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүн дараахь үүрэгтэй:

11.1.1. хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой болсон нөхцөл, шалтгааны талаар эрүүл мэндийн байгууллагад үнэн зөв мэдээлэл өгөх;

11.1.2. эрүүл мэндийн байгууллагын шаардлагын дагуу заасан хугацаанд эмнэлгийн үзлэг, шинжилгээ хийлгэх;

11.1.3. эмнэлгийн тусламж авах бүртээ хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой тухайгаа эрүүл мэндийн байгууллагад заавал мэдэгдэх;

11.1.4. цус, бусад эд, эрхтэний донор байхаас татгалзах;

11.1.5. халдварыг бусдад тараахгүй байх, тарааж болох аливаа үйлдлээс татгалзах, өөрийгөө болон бусдыг хамгаалах;

11.1.6. эрүүл мэндийн байгууллага,

эмч, эмнэлгийн мэргэжилтнээс өгсөн зөвлөгөө, зааварчилгааг чанд сахин биелүүлэх;

11.1.7. хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон бол энэ тухайгаа өөрийн эхнэр /нөхөр/, хамтран амьдрагчид нэн даруй мэдэгдэх.

11.2. Гадаадад оршин сууж байсан Монгол Улсын иргэн хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой бол Монгол Улсад орж ирэхдээ улсын хилийн эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагад энэ тухайгаа мэдэгдэх үүрэгтэй.

11.3. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой нь тогтоогдсон гадаадын иргэн Монгол Улсын эрүүл мэндийн байгууллагын хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс зайлсхийвэл түүнийг хууль тогтоомжид заасны дагуу тус улсаас албадан гаргана.

12 дугаар зүйл. Хэвлэл, мэдээллийн болон шашны байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоо

12.1. Хэвлэл, мэдээллийн болон шашны байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх, тэмцэх талаар хүн амын дунд зохиох сургалт, сурталчилгааны ажилд оролцоно.

13 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдэд хүлээлгэх хариуцлага

13.1. Хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээрэй бол сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга гэм буруутай этгээдэд дор дурдсан захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

13.1.1. энэ хуулийн 7.1.3-ыг зөрчсөн бол аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг 20000-50000 төгрөгөөр торгох;

13.1.2. энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлээгүй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг 20000-50000 төгрөгөөр торгох;

13.1.3. энэ хуулийн 10 дугаар зүйлийг зөрчсөн бол иргэнийг 20000-50000, албан тушаалтныг 40000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000-250000 төгрөгөөр торгох;

13.1.4. энэ хуулийн 11 дүгээр зүйлийг зөрчсөн бол иргэнийг 20000-50000 төгрөгөөр торгох.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1993 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль хүчин төгөлдөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 5 дугаар сарын 14-ны өдөр

Улаанбаатар хот

МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, оролцогчдын эрх, үүрэг

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

4 дүгээр зүйл. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт

2 дугаар зүйл. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж

4.1.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, аймаг, нийслэл, сум, дүүрэгт түүний салбар зөвлөл зохицуулна.

2.1.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль¹, Эрүүгийн хууль², Эрүүгийн байцаан шийтгэх хууль³, Иргэний хууль⁴, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль⁵, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

4.2.Энэ хуулийн 4.1-д заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ ажлыг зохион байгуулж болно.

3 дугаар зүйл. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үндсэн зарчим

5 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үүрэг

3.1.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил нь хууль дээдлэх, өмчлөгчийн эрхийг хамгаалах, олон нийтийн хүчинд түшиглэх, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүр малаа гэмт халдлагаас хамгаалах үүрэг хүлээх, төрийн байгууллага мал хулгайлах гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах ажлыг зохион байгуулах зарчимд тулгуурлана.

5.1.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1.харьяа нутаг дэвсгэртээ мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;

5.1.2.мал хулгайлах гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг судлан, арилгах арга хэмжээг зохион байгуулах;

5.1.3.мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийг

¹ Монгол Улсын Үндсэн хууль -Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

² Эрүүгийн хууль -Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

³ Эрүүгийн байцаан шийтгэх хууль -Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Иргэний хууль -Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль -Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

татан оролцуулж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагад дэмжлэг тусалцаа үзүүлэх;

5.1.4.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа мал сүргээ хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

5.1.5.төв суурин газар, хүнсний зах, махны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж зэрэг шаардлагатай газарт мал, мах бэлтгэх төвлөрсөн цэг тогтоож, мал, махны гарал үүсэлд хяналт тавих;

5.1.6.малыг им, тамга, зүсийн бүртгэл, өдрийн хариулга, шөнийн манаатай болгох, эрүүл, харуул ажиллуулах ажлыг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулах, энэ хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэл санаачлагыг дэмжих;

5.1.7.шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагатай хамтран энэ хуулийн 7.1.1-д заасан им тамга, бүртгэлтэй тулгаж, хэсэгчилсэн буюу ганцаарчилсан хяналтын тооллого явуулах;

5.1.8.бод малыг улсын хэмжээнд индексжүүлсэн тамгын сүлжээнд хамруулах ажлыг зохион байгуулах.

5.2.Энэ хуулийн 5.1.8-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

6 дугаар зүйл.Хууль хяналтын байгууллагын үүрэг

6.1.Хууль хамгаалах болон мэргэжлийн хяналтын байгууллага мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, үйлдэгдсэн гэмт хэргийг бүрэн илрүүлэх, хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг хамтран зохион байгуулна.

7 дугаар зүйл.Мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

7.1.Мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

7.1.1.өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа малаа им тамга, бусад таних тэмдэгтэй болгох, бод малд зүсийн бүртгэл хөтлөх;

7.1.2.уламжлалт им тамгын зэрэгцээ бод малаа энэ хуулийн 5.1.8-д заасан индексжүүлсэн тамгын сүлжээнд хамруулах;

7.1.3.малаа байнгын хариулга, манаатай байлгаж хулгайд алдахгүй байх бусад арга

хэмжээг орон нутгийн болон улирлын онцлог, боломжид тохируулан авах;

7.1.4.малыг бусдын өмчлөлд шилжүүлэх тохиолдолд мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ авч, нэг бүрчилсэн бүртгэлийг гэрээнд хавсаргах.

8 дугаар зүйл.Мал, махны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

8.1.Мал, махны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар дараахь үүрэг хүлээнэ:

8.1.1. мал, мах бэлтгэх ажлыг бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэх;

8.1.2.мал, мах бэлтгэх, худалдах-худалдан авах гэрээ болон түүний хавсралт, эрүүл ахуй, ариун цэврийн сертификатыг 6 сар хүртэл хугацаагаар хадгалж байх;

8.1.3.амьдын жингээр авч нядалж, бэлтгэж байгаа малын толгой, арьс, ширийг анхан шатны боловсруулалт хийж, нядалгаа хийснээс хойш 3 хоног хадгалж, эрх бүхий албан тушаалтанд саадгүй үзүүлж байх;

8.1.4.мал, мах бэлтгэх ажлыг энэ хуулийн 5.1.5-д заасан цэгт хийх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр

9 дүгээр зүйл.Малыг бусдын өмчлөлд шилжүүлэхэд тавигдах шаардлага

9.1.Малыг зөвхөн Иргэний хуульд заасан холбогдох гэрээний үндсэн дээр бусдын өмчлөлд шилжүүлнэ.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан гэрээнд бусдын өмчлөлд шилжүүлж байгаа малын нэг бүрчилсэн бүртгэлийг хавсаргасан байна.

9.3.Энэ хуулийн 9.2-т заасан бүртгэлд малын төрөл, нас, хүйс, им тамганы талаар тодорхой заасан байна.

10 дугаар зүйл.Мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ

10.1.Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төв суурин газарт борлуулах, худалдах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, маханд мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ олгоно.

10.2.Мал, мах бэлтгэх гарал үүслийн

гэрчилгээний загвар, олгох журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

11 дүгээр зүйл. Алдуул малыг бүртгэх, мэдээлэх

11.1. Нутгийн захиргааны байгууллага алдуул малыг бүртгэж, алдуул малын талаар цагдаагийн байгууллага болон олон нийтэд тогтмол мэдээлж байна.

11.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага алдуул малын талаар нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

11.3. Алдуул малыг өөрийн эзэмшилд байлган маллаж байсан этгээдэд Иргэний хуулийн 116, 117 дугаар зүйлд заасан урамшуулал олгоно.

12 дугаар зүйл. Отрын болон туувын малд бүртгэл хөтөлж

12.1. Мал бүхий иргэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэг нэгжээс өөр нэгжид түр хугацаагаар оторлох болон тууварлах, шилжин суурьших тохиолдолд тухайн малчин малдаа бүртгэл хөтөлнө.

12.2. Энэ хуулийн 12.1-д заасан бүртгэлд малын төрөл, тоо толгой, нас, хүйс, зүс, им тамга, оторлох нутаг, хугацаа, оторлох, тууварлах буюу шилжин суурьших засаг захиргааны нэгжийг заах бөгөөд уг бүртгэлийг тухайн сум, дүүргийн Засаг дарга батламжилна.

13 дугаар зүйл. Мал туувын зам тогтоох

13.1. Сум, дүүргийн нутаг дэвсгэрээр мал туувар дайран өнгөрөх орон нутгийн туувын замын маршрутыг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүсийн маршрутыг Бүсийн захирагч, бүс хоорондын маршрутыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Бүсүүдийн захирагч нартай хамтран тус тус тогтооно.

14 дүгээр зүйл. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах

14.1. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу урамшуулна.

15 дугаар зүйл. Мал хулгайлах гэмт хэргийн тухай мэдээллийг иргэдээс төлбөртэй авах

15.1. Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай мэдээлэл үндэслэлтэй болох нь тогтоогдсон тохиолдолд цагдаагийн байгууллага Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу мэдээлэл

худалдаж авсны төлбөр олгоно.

15.2. Мэдээлэл үндэслэлтэй болох нь шүүхийн шийтгэх тогтоолоор нотлогдсон тохиолдолд хулгайд алдагдсан малын өмчлөгч нь буцаан олж авсан малын тоо толгойн буюу хохирлоо нөхөн төлүүлсэн үнийн дүнгийн 10 хуртлал хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг мэдээлэгчид олгож болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилт

16 дугаар зүйл. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сан

16.1. Энэ хуулийн 4.1-д заасан салбар зөвлөлийн дэргэд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тусгай сан байгуулж болно.

16.2. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн үлгэрчилсэн дүрмийг Засгийн газар батална.

16.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн дүрмийг орон нутгийн онцлогт тохируулан батална.

16.4. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх санд гадаад, дотоодын иргэд, байгууллагын тусламж, хандив болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлж болно.

16.5. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн хөрөнгийг дараахь зориулалтаар зарцуулна:

16.5.1. мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, энэ гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, арилгах;

16.5.2. мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үүрэг гүйцэтгэж байгаа эргүүл, жижүүр, харуулыг урамшуулах;

16.5.3. мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

17 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

17.1. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

150000 хүртэл төгрөгөөр торгох;

17.1.3.энэ хуулийн 8.1.3-т заасныг зөрчсөн иргэнийг 40000 хүртэл, аж ахуйн нэгж, байгууллагыг 200000 хүртэл төгрөгөөр торгох.

18 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

18.1.Энэ хуулийг 2004 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

17.1.1.гарал үүслийн гэрчилгээгүй мал, мах тээвэрлэсэн, тусгайлан бэлтгэсэн төвлөрсөн цэгээс өөр газарт мал, мах бэлтгэсэн бол хууль бусаар бэлтгэсэн, тээвэрлэсэн мал, махыг хурааж, зөрчил гаргасан иргэнийг 50000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000 хүртэл төгрөгөөр торгох;

17.1.2.энэ хуулийн 12.1-д заасан бүртгэлгүйгээр мал тууварласан, оторлосон, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон мал тууварын замаас өөр замаар мал тууварласан иргэнийг 30000 хүртэл, аж ахуйн нэгж, байгууллагыг

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2004 оны 5 дугаар
сарын 14-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 49.2-ын "хэрэгслийг" гэсний өмнө "тээврийн болон бусад", 145.2-ын "учирсан" гэсний дараа "олон тооны мал хулгайлсан" гэж тус тус нэмсүгэй.

арилгасан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно." гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 71.1-ийг "Энэ хуулийн тусгай ангийн 145.1/Бусдын эд хөрөнгийг хулгайлах/-д зааснаас бусад хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэм буруутай этгээд хохирогчтой сайн дураараа эвлэрсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг

3 дугаар зүйл. Энэ хуулийг Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2004 оны 5 дугаар
сарын 14-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 25.1-ийг "Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145.1/Бусдын эд хөрөнгийг хулгайлах/-д зааснаас бусад хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн бөгөөд гэмт хэргийн хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй сайн дураараа эвлэрсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгоно." гэж өөрчлөн найруулсугай.

хулгайлах/ " гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27.3-ын "145.2/Бусдын эд хөрөнгийг

3 дугаар зүйл. Энэ хуулийг Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2004 оны 5 дугаар
сарын 14-ны өдөр**

**Улаанбаатар
хот**

ЗАРИМ БАРААНД НОГДУУЛАХ ЭКСПОРТЫН ГААЛИЙН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуулийн 1 дүгээр зүйлийн хүснэгтийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь хэсгийн Гаалийн татварын хэмжээ /төгрөгөөр/ "140" гэснийг "350" гэж тус тус

өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР**



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

тэмцэх үндэсний хөтөлбөр батлан, хэрэгжүүлэх;

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н. Энхбаяр/-т даалгасугай:

2/хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авах.

1/гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор шүүгч, прокурор, цагдаагийн болон нийгмийн ажилтныг давтан сургах, иргэний нийгмийн оролцоог өргөжүүлэх зорилгоор гэр бүлийн хүчирхийлэлтэй

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо /Г.Ганди/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Хуулиудын төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-т заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

оруулах тухай. Тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2004 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн хуулийн 3 дугаар зүйлийн 1-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 86 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

"Норматив тогтоох тухай" Улсын Их Хурлын

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 14-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

"Энхийн төлөө" медаль бий болгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

иргэнийг шагнах "Энхийн төлөө" медаль бий болгосугай.

1. НҮБ-ын энхийг сахиулах хүчин, олон улсын бусад ажиллагаанд оролцсон цэрэг, цагдаагийн албан хаагчид, энхийг сахиулах, хүмүүнлэгийн асуудлаар идэвхтэй ажиллаж, амжилт гаргасан гадаадын болон Монгол Улсын

2. "Энхийн төлөө" медалийн загварыг 1 дүгээр хавсралтаар, "Энхийн төлөө" медалийн тодорхойлолт, шагнах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

С.ТӨМӨР-ОЧИР

"ЭНХИЙН ТӨЛӨӨ" МЕДАЛИЙН ЗАГВАР



Монгол Улсын Их Хурлын 2004 оны 33 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"ЭНХИЙН ТӨЛӨӨ" МЕДАЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ШАГНАХ ЖУРАМ

Нэг. "Энхийн төлөө" медалийн тодорхойлолт

1. "Энхийн төлөө" медалийн үндсэн хэсэг нь алтан шар өнгийн 1 мм хүрээ бүхий 4 см-ийн голчтой бор шаргал өнгөтэй, дугуй хэлбэртэй байна. Медалийн төв хэсэг нь 2 см-ийн голч бүхий дэлхийн бөмбөрцгийг Евро-Азийн талаас нь товойлгон дүрсэлсэн, түүнийг тойрсон 3 см-ийн голч бүхий 1 мм-ийн өргөн алтан шар хүрээ байна.

2. Дэлхийн бөмбөрцгийн дээд хэсэгт алтан шар өнгөөр товойлгон дүрсэлсэн соёмботой байна.

3. Бамбайн доод хэсэгт хоёр хүрээний хооронд "Энхийн төлөө" гэсэн үгийг шар өнгөөр кирилл монгол үсгээр товойлгож бичсэн байна.

4. Медалийн зүүлтийн хэсэг нь 30x25 мм-ийн хэмжээтэй, 2.5 мм-ийн өргөн алтан шар өнгийн хүрээтэй, хөх цэнхэр өнгийн суурьтай, гурвалжин хэлбэртэй байх бөгөөд дундаа 2.5 мм-ийн өргөн хоёр эгнээ шар зураастай байна.

5. Медалийг зүүлтэй нь алтан шар өнгийн

гархиар холбоно, зүүлтийн ар талд хувцсанд тогтоох зүүтэй байна.

Хоёр: "Энхийн төлөө" медалийн бэлгэдлийн тайлбар

1. "Энхийн төлөө" медалийн үндсэн суурь нь Монгол цэргийн уламжлалт эртний бамбайн хэлбэрийг дүрсэлсэн, уг бамбай нь халдах дайсан, хар санааг халхлан хамгаалах гэсэн утгыг илэрхийлнэ.

2. Бамбайн төв хэсэгт дэлхийн бөмбөрцгийг байрлуулсан нь дэлхий ертөнцийг энхийн үйлсээр хамгаална гэсэн утгыг тодорхойлно.

3. Бамбайн дээд хэсэгт төрийн алтан соёмбо тэмдгийг байрлуулсан нь Монгол төрийн цэрэг гэсэн утгыг агуулна.

4. Бамбайн доод хэсэгт "Энхийн төлөө" гэж алтан шар өнгөөр кирилл монгол үсгээр товойлгон бичсэн нь дэлхий ертөнцийн энх амгалан сайн сайхны төлөө тэмцэгч гэсэн утгатай үг болно.

5. Медалийн зүүлтийн гурвалжин хэлбэр нь өнө мөнхөд тогтвортой байх гэсэн утгыг илэрхийлнэ.

6. Зүүлтийн гурвалжны өнгө нь цэлмэг хөх тэнгэрийг, хоёр хос шар зураас нь одоо ба ирээдүйг бэлгэдсэн байна.

Гурав: "Энхийн төлөө" медалиар шагнах журам.

1. "Энхийн төлөө" медалийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-ыг үндэслэн НҮБ-ын

энхийг сахиулах хүчин, олон улсын бусад ажиллагаанд оролцсон цэрэг, цагдаагийн албан хаагчид, энхийг сахиулах, хүмүүнлэгийн асуудлаар идэвхтэй ажиллаж, амжилт гаргасан гадаадын болон Монгол Улсын иргэнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар олгоно.

2. "Энхийн төлөө" медалиар шагнуулах тухай тодорхойлолтыг зохих журмын дагуу эрх бүхий байгууллага батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3. Шагнагдах хүмүүсийн материалыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт өргөн мэдүүлж, шийдвэрлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 5 дугаар сарын 14-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Үнэт цаасны хорооны гишүүнийг чөлөөлөх, томилох тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 32.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Гадаадад удаан хугацаагаар ажиллах болсон тул Содномын Ганболдыг Үнэт цаасны хорооны гишүүнээс чөлөөлж, Намжилдоржийн

Энхбаярыг Үнэт цаасны хорооны гишүүнээр томилсуйг.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 5 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 87

Улаанбаатар хот

Паавангийн Дамдинд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат ажилтан цол хүртээх тухай

Төрийн болон төрийн бус байгууллагад он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж Монгол Улсын аж үйлдвэржүүлэх бодлогыг боловсруулж амьдралд хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах үйлст оруулсан дорвитой хувь нэмрийг нь үнэлж үйлдвэр худалдааны "Товь" ХК-

ийн зөвлөх Паавангийн Дамдинд Монгол Улсын аж үйлдвэрийн гавъяат цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 5 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 88

Улаанбаатар хот

Нямын Ширнэндугарт Монгол Улсын гавъяат тээвэрчин цол хүртээх тухай

Төмөр замын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж галт тэрэгний хөдөлгөөнийг удирдан зохицуулах хариуцлагатай үүргийг амжилттай гүйцэтгэж, тээврийн төлөвлөгөөт зорилт, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улаанбаатар төмөр замын Улаанбаатар өртөөний

сэлгээний зохицуулагч Нямын Ширнэндугарт Монгол Улсын гавъяат тээвэрчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н. БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 5 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

Зарим багш нарт Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургуульд багшаар олон жил үр бүтээлтэй ажиллаж заах аргын ур чадвар, сургалтын чанарыг дээшлүүлэн, өсвөр үеийнхэнд боловсрол эзэмшүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан багш нарт Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

2. Дагвахуугийн Нямсүрэн -Говь-Алтай аймгийн Есенбулаг сумын 10 жилийн нэгдүгээр сургуулийн бага ангийн багш

1. Жамцын Баасанжав - О р х о н аймгийн Баян-Өндөр сумын 10 жилийн нэгдүгээр сургуулийн биологийн багш

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 5 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 90

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, банк, радио, соёл урлаг болон төрийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж

байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Голиминсээгийн Шилагарди МУИС-ийн Физик, электроникийн сургуулийн физикийн салбарын зөвлөх профессор

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Сономын Адъяа Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын Тамгын газрын дарга

9. Товуучийн Бямбадорж Монголын үндэсний радиогийн нийгэм, эдийн засаг, бизнесийн албаны тоймч

2. Бэгзжавын Алтангэрэл Говь-Алтай аймгийн Есенбулаг сумын 1 дүгээр дунд сургуулийн математикийн багш

10. Пүрэвдагвын Бямбасүрэн "Капитрон" банкны Зээлийн эдийн засгийн газрын захирал

3. Чимэдийн Баатар Дамжуулах байгууламж, радио, телевизийн техникийн төвийн харъяа УКВ станцын ерөнхий инженер

11. Пүрэвсүрэнгийн Гочоо Булган аймгийн Орхон сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга

4. Баатарын Бадамханд Халдварт өвчин судлалын үндэсний төвийн сурьезгийн тандалт судалгааны албаны гэрлийн их эмч

12. Нягжавын Даваажав Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын авто баазын захиргаа, аж ахуйн албаны дарга

5. Дэнсмаагийн Баяр Монгол шуудан банкны дэд захирал

13. Дэжидийн Дамдин Хөвсгөл аймгийн Их-Уул сумын 10 жилийн дунд сургуулийн математикийн багш

6. Лхамсүрэнгийн Бордух Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн ерхийн эмч

14. Лувсандоржийн Дамдинсүрэн Төв аймгийн Аргалант сумын 10 жилийн дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

7. Жагваралын Буд Өмнөговь аймгийн Даланзадгад сумын "Говийн оргил" хоршооны эзэн

15. Цэрэнгийн Дамдинсүрэн Улаанбаатар төмөр замын Улаанбаатар ертөөний ачааны зохицуулагч

8. Абзодын Буйдахмет Монголын үндэсний радиогийн "Хурд" агентлагийн хариуцлагатай редактор

16. Гочоогийн Дармаа Завхан аймгийн Тосонцэнгэл сумын өндөр настан, ахмад шүүгч



17.Түнтүүгийн Дарьсүрэн
Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар
багт малчин

18.Шаарийбуугийн Дирваа
"Монгол шуудан" ХХК-ийн Улаанбаатар хот
дахь холбооны 21 дүгээр салбарын эрхлэгч

19.Төмөрдөөгийн Дуламжав
Завхан аймгийн Тосонцэнгэл сумын 10
жилийн 2 дугаар дунд сургуулийн газар зүйн багш

20.Дондогжанцангийн Дуламхүү
Халдварт өвчин судлалын үндэсний
төвийн сурьээгийн клиникийн хүүхдийн тасгийн
эрхлэгч

21.Лочингийн Дэнсмаа
Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн
хүүхдийн их эмч

22.Намхайдоржийн Ёндон
МУИС-ийн Математик компьютерийн
сургуулийн алгебрын тэнхмийн багш

23.Дамбажамцын Жамъянсүрэн
Клиникийн 3 дугаар нэгдсэн эмнэлгийн мэс
заслын их эмч

24.Равдангийн Лутаа
Нийслэлийн "Тяхько" ХК-ийн Төлөөлөн
удирдах зөвлөлийн дарга

25.Маслов Валерий Иванович
Улсын клиникийн төв эмнэлгийн дүрс
оношлогооны тасгийн дурангийн багийн ахлагч, их
эмч

26.Хөхийн Монхoo
Нийслэлийн Баянгол дүүргийн 10 жилийн
13 дугаар дунд сургуулийн биеийн тамирын багш

27.Сүрэнгийн Мөөмөө
Улаанбаатарын их сургуулийн хэл утга
зохиолын факультетийн багш

28.Дэмчигдоржийн Мямгарсүрэн
Монголын үндэсний радиогийн редактор

29.Лувсандоржийн Насанбат
Улаанбаатар төмөр замын Улаанбаатар
суудлын вагон делогоийн орлогч дарга

30.Жанцансамбуугийн Нацагдорж
Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх
Боловсрол, соёлын газрын орлогч дарга

31.Дамбаравжаагийн Олзод
Төв аймгийн Зуунмод сумын "Хүмүүн"
цогцолбор дунд сургуулийн газар зүйн багш

32.Далхсүрэнгийн Оюун
Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10 жилийн
1 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш

33.Цэдэн-Очирын Пагмажав
Хөвсгөл аймгийн Мөрөн сумын
"Дэлгэрмөрөн" цогцолборын 1 дүгээр сургуулийн
монгол хэл, уран зохиолын багш

34.Чүлтэмийн Пэрэнлэй
Хүнс, хөдөө аж ахуйн яамны хөдөө аж ахуйн
сангийн хэлтсийн дарга

35.Сүрэнгийн Сандагдорж
Монголын үндэсний радиогийн гадаад
мэдээний хариуцлагатай редактор

36.Ёндонгийн Санжмаа
Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн
механикч

37.Баттогтохын Содномбалжир
Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн
44 дүгээр дунд сургуулийн сургалтын менежер

38.Ядамжавын Сумъяа
МОНЦАМЭ агентлагийн дотоод мэдээллийн
газрын дарга, "МОНЦАМЭ" сэтгүүлийн эрхлэгч

39.Кызылын Төлөөгөн
Улаанбаатар төмөр замын материал
техникээр хангах баазын дарга

40.Лантуугийн Хандсүрэн
Техник-технологийн коллежийн боловсон
хүчин, бичиг хэргийн эрхлэгч

41.Аюушийн Хашбаатар
МУИС-ийн Математик, компьютерийн
сургуулийн математикийн дидактик, геометрийн
тэнхмийн багш

42.Түвдэнгийн Хишигжаргал
Нийслэлийн Баянгол дүүргийн "Эрдмийн
өргөө" цогцолбор сургуулийн математикийн багш

43.Лодоншаравын Цэвэлмаа
Улсын клиникийн төв эмнэлгийн радио
химийн их эмч

44.Цэвэгжавын Цэвээн
МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн
менежментийн тэнхмийн багш

45.Өлөгчөөгийн Цэдэндамба
Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн
газрын хэлтсийн дарга

46.Чимэдцэрэнгийн Цэдэн-Иш
Нийслэлийн "Цэ энд Пү" эрэгтэйчүүдийн
хувийн эмнэлгийн захирал

47.Уржингийн Цэрэндэжид
Улаанбаатар төмөр замын 5 дугаар
цэцэрлэгийн эрхлэгч

48.Ханагатын Цэрэг
Ховд аймгийн Ховд сумын 10 жилийн дунд
сургуулийн захирал

49.Бираагийн Цэрэннадмид
Увс аймгийн Өндөрхангай сумын хүний
эмнэлгийн хүүхдийн их эмч

50.Дэмидийн Цэрэнханд
Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн
"Ирээдүй" цогцолборын 2 дугаар дунд сургуулийн
түүх, эрх зүйн багш

51. Батаагийн Чанцалдулам
Улаанбаатар төмөр замын Дуу, бүжгийн
чуулгын гоцлол хөгжимчин

52. Агваанхандын Чойдорж
Улаанбаатар төмөр замын боловсон
хүчин, үйлчилгээний албаны тэргүүлэх инженер

Хавтгайн Дамжин
- Нийслэлийн Гал түймэртэй тэмцэх хэлтсийн
гал унтраах 28 дугаар ангийн захирагч, дэд хурандаа

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Самбуугийн Алтангэрэл
Нийслэлийн Баянзүрх дүүргийн 87 дугаар
дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

2. Сагдагдоржийн Алтанцэцэг
Дамжуулах байгууламж, радио телевизийн
техникийн төвийн радио нэвтрүүлэх төв станцын
ээлжийн ахлагч

3. Дамдинпүрэвийн Амаржаргал
Монголын үндэсний радиогийн "Хурд"
агентлагийн хариуцлагатай редактор

4. Цэрэвийн Амраа
Увс аймгийн Хөгжимт драмын театрын
хөгжмийн багш

5. Дэлэгийн Баасгай
Улаанбаатар төмөр замын барилга
үйлдвэрлэлийн нэгдлийн дарга

6. Дашдэлэгийн Баатарчулуун
Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн
"Ирээдүй" цогцолборын 2 дугаар дунд сургуулийн
орос хэлний багш

7. Осорын Баасанжав
Хөвсгөл аймаг дахь Мэргэжлийн сургалт
үйлдвэрлэлийн төвийн инженер багш

8. Осорын Бадарч
Дамжуулах байгууламж, радио телевизийн
техникийн төвийн цахилгааны инженер

9. Батын Балдир
Архангай аймгийн Эрдэнэмандал сумын 10
жилийн дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын
багш

10. Далхаагийн Бариваан
Дамжуулах байгууламж, радио телевизийн
техникийн төвийн харъяа УКВ станцын инженер

11. Сэрэнэндоржийн Батбаяр
ХААН банкны "Баруун хүрээ" салбарын
захирал

12. Элбэгийн Батдорж
Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношлогоо,
эмчилгээний төвийн зөвлөх эмч

53. Довдондоржийн Чойжилсүрэн
Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс
заслын зөвлөх, их эмч

54. Чагдагийн Энхтунгалаг
Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 10 жилийн
дунд сургуулийн захирал

13. Бямбын Баттулга
Дундговь аймгийн Луус сумын мал
эмнэлэг, үржлийн албаны "Салхит" ХК-ийн захирал

14. Тонгошийн Баярмагнай
Дамжуулах байгууламж, радио телевизийн
техникийн төвийн харъяа Говь-Алтай аймаг дахь
радио өргөн нэвтрүүлэх станцын техникч

15. Цэрэнпунцагийн Болдбаатар
Үндэсний архивын газрын ерөнхий нягтлан
бодогч

16. Батсүхийн Боролзой
Дамжуулах байгууламж, радио телевизийн
техникийн төвийн харъяа Өмнөговь аймаг дахь радио
өргөн нэвтрүүлэх станцын ээлжийн ахлагч

17. Гомпилын Буд
Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын
төвийн үйлдвэрийн "Цацрал" чуулгын хөгжимчин

18. Дондоын Бумцэнд
Улаанбаатар төмөр замын Дархан татах
хэсгийн машинч

19. Шунхайн Галсандорж
Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 3 дугаар
дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

20. Жамьянгийн Ганбат
"Голомт" банкны дотоод хяналтын хэлтсийн
захирал

21. Ёнзонгийн Ганчимэг
"Капитрон" банкны 1 дүгээр салбарын эдийн
засагч

22. Лхамжавын Гэрэлмаа
Дамжуулах байгууламж, радио телевизийн
техникийн төвийн аймаг дахь радио өргөн
нэвтрүүлэх станцын дарга

23. Сийсаагийн Даваа
Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн
44 дүгээр дунд сургуулийн физик, математикийн
багш

- | | |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 24. Чойжамцан Дашцэрэн
Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн ажилчин | 38. Чогсомжавын Намжин
Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Хөтөлийн 10 жилийн дунд сургуулийн бага ангийн багш |
| 25. Хасын Доржмаа
Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10 жилийн 2 дугаар дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш | 39. Магвандоржийн Нансалмаа
Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Эрдэнэт" цогцолбор сургуулийн орос хэлний багш |
| 26. Цэрэндоржийн Дуламсүрэн
Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга | 40. Шаравдоржийн Норжмаа
Кредит банкны Дархан-Уул аймаг дахь салбарын 13 дугаар тооцооны төвийн эрхлэгч |
| 27. Дамдингийн Дүгэр
Капитал банкны эзэлийн хэлтсийн захирал | 41. Чимэддоржийн Нэргүй
Нийслэлийн Татварын газрын татварын улсын байцаагч |
| 28. Самбуугийн Дүгэрсүрэн
Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн 33 дугаар дунд сургуулийн бага ангийн багш | 42. Дамдингийн Нядааноров
Улаанбаатар төмөр замын зам засварын машинт станцын сантехникийн механикч |
| 29. Санжмятавын Дэлэг
Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 119 дүгээр цэцэрлэгийн багш | 43. Дамдинсүрэнгийн Нямаа
Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан |
| 30. Төлеубайн Ерэн
Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Цагаан Арал багийн бага эмч | 44. Дамдинсүрэнгийн Ордос
Улаанбаатар төмөр замын Барилга орон сууцны 1 дүгээр ангийн Орхонтуул хэсгийн уурын зуухны мастер |
| 31. Лунбангийн Жанцандорж
Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны улсын байцаагч | 45. Цэрэннадмидын Оюунбаатар
Түлш, эрчим хүчний ерөнхий газрын түлшний албаны инженер |
| 32. Гозгорын Лхагвасүрэн
Улсын клиникийн төв эмнэлгийн мэс заслын клиникийн ахлах сувилагч | 46. Ванганы Оюунгэрэл
Худалдаа, хөгжлийн банкны тооцооны 3 дугаар төвийн эрхлэгч |
| 33. Чойжилын Лхамсүрэн
Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын 10 жилийн дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш | 47. Норовын Оюундэлгэр
Улсын клиникийн төв эмнэлгийн цус, булчирхайн клиникийн тасгийн эрхлэгч, их эмч |
| 34. Цэрэндоржийн Минжүүр
Улсын клиникийн төв эмнэлгийн дотрын их эмч | 48. Шаравын Оюунсүрэн
Монголбанкны мөнгөн тэмдэгийн хэлтсийн хянагч |
| 35. Самбуугийн Мөнхдэлгэр
Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 10 жилийн 2 дугаар дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш | 49. Лхасүрэнгийн Пагма
Худалдаа хөгжлийн банкны Сэлэнгэ аймаг дахь салбарын ахлах нярав |
| 36. Цэвэлийн Мягмарсүрэн
Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 10 жилийн 105 дугаар дунд сургуулийн монгол хэлний багш | 50. Мятавын Пүрэвдорж
Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Хөтөлийн 10 жилийн дунд сургуулийн математикийн багш |
| 37. Чимэддоржийн Нарантуяа
Улаанбаатар төмөр замын Зүүнхараа нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч | 51. Өлзийбатын Пүрэвхүү
Улсын клиникийн төв эмнэлгийн цус, булчирхайн клиникийн ахлах сувилагч |

52.Банзарын Сарангэрэл
Үндэсний статистикийн газрын макро эдийн засаг, бизнес статистикийн газрын ахлах мэргэжилтэн

53.Пүрэвийн Соёлдагэр
Монголын үндэсний радиогийн уран зохиол, урлаг соёлын албаны редактор

54.Дамдингийн Тавхар
Булган аймгийн Хишиг-Өндөр сумын 10 жилийн дунд сургуулийн хими, биологийн багш

55.Дугараагийн Туяа
Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын Засаг дарга

56.Цэрэнтулгын Түмэнбаяр
Утга зохиол, нийгмийн ажилтны дээд сургуулийн багш, зохиолч

57.Чулууны Хоролсүрэн
Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн ажилчин

58.Жанцангийн Цогзолмаа
Улаанбаатар төмөр замын Улаанбаатар суудлын вагон депогийн вагоны үйлчлэгч

59.Сэнгээрэйн Цэвэгжав
Монголын үндэсний радиогийн инженер

60.Лааганы Цэгмид
Хөвсгөлд аймгийн Мөрөн сумын 5 дугаар багийн Засаг дарга

61.Батмөнхийн Цэрэндорж
Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 10 жилийн 67 дугаар дунд сургуулийн математикийн багш

62.Лувсангийн Цэцэгэ
Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн мэс заслын ахлах сувилагч

63.Батсуурийн Цэцэгмаа
"Анод" банкны дотоод хяналтын газрын захирал

64.Шаравын Цэдэвдолгор
-Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын авто тээврийн хяналтын улсын байцаагч

65.Чүлтэмийн Чулуунцэцэг
ХААН банкны Дархан-Уул аймаг дахь салбарын захирал

66.Лувсангийн Шархүү
Улаанбаатар төмөр замын Сайншанд татах хэсгийн илчт тэрэгний машинч

67.Галсансамбуугийн Шархүүхэн
Нийслэлийн Хан-Уул дүүргийн 72 дугаар цэцэрлэгийн багш

68.Мажиграгчаагийн Шашмаа
ХААН банкны Сүхбаатар аймгийн Онгон сум дахь тооцооны төвийн эрхлэгч

69.Хиланбайн Шигдэбай
Ховд аймгийн Ховд сумын 10 жилийн дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

70.Бадарчийн Явжин
"Капитал" банкны ахлах нягтлан бодогч

**МОНГОЛУЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 88

Улаанбаатар хот

Загвар, заавар батлах тухай

Улсын Их Хурлын 2004 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүний хэрэгжилтийг хангахад баримтлах журам"-ын 3.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төслийг боловсруулах нийтлэг загварыг 1 дүгээр хавсралт, загварыг ашиглахад баримтлах зааврыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Загвар, зааврыг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн

төслийг боловсруулах үйл ажиллагаандаа баримтлан ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Нийтлэг загвар, зааврын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.ЭНХБАЯР

**САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД**

Ч.УЛААН

**ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЗАГВАР**

.....
(БАЙГУУЛЛАГЫН НЭР)



**ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 20... ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ,
20...-20... ОНЫ ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА**

.....
(аймаг, хотын нэр)

20... оны ... сар

1. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН МЭДЭГДЭЛ

.....
.....
.....
.....

.....-ИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
(БАЙГУУЛЛАГЫН НЭР)

.....
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(овог, нэр)

200... оны... сарын ...-ны өдөр

2. ТАНИЛЦУУЛГА

2.1 ийн салбарын хөгжлийн өнөөгийн байдал

(Салбарын нэр)

(..... аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал)

(Аймгийн нэр)

2.2. 20... оны үндсэн чиглэлд тусгах бодлогын зорилт, арга хэмжээ,

20...-20... оны хөгжлийн хандлагын талаархи танилцуулга

2.2.1. 20... оны үндсэн чиглэлд тусгах бодлогын зорилт,

арга хэмжээний тухай

2.2.2. 20...-20... оны хөгжлийн хандлага, бодлогын зорилт

3. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 20... ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАХ БОДЛОГЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ МАТРИЦ

БОДЛОГЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	ҮНДСЭЛЭЛ, ТАЙЛБАР	ХУГАЦАА (улирлаар)	ЗАРДАЛ: -Эх үүсвэр - Хэмжээ, ая төгрөг	БОДЛОГО, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭЭД ХҮРЭХ ҮР ДҮН
1 Бодлогын зорилт				
1.1-Арга хэмжээ				
1.2-Арга хэмжээ				
1.3-Арга хэмжээ				
1.4-Арга хэмжээ				
...				
2 Бодлогын зорилт				
2.1-Арга хэмжээ				
2.2-Арга хэмжээ				
2.3-Арга хэмжээ				
...				

4. ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨТӨЛБӨР, ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХӨРӨНГӨ САНХҮҮГИЙН ХУВЬД ХҮНДРЭЛТЭЙ БАЙГААГААС ТАСАРЧ БОЛЗОШГУЙ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Арга хэмжээ	Хөтөлбөр, төсөлд туссан байдал	Шаардагдах хөрөнгө, (ая төгрөг)	Хэрэгжүүлсэн байх эцсийн хугацаа	Гарах үр дүн
1.					
2.					
3.					
...					



5. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

Д/Д	Төсөл, арга хэмжээний нэр	Саяоогуултийн хуваарь, сая төгрөгөөр						Төсөл, арга хэмжээний үр дүнгийн үзүүлэлт
		200...оны гүйцэтгэл	200...оны ХБГ	20...оны төсөл	20...оны төсөөлөл	20...оны төсөөлөл	20...оны төсөөлөл	
1								
2								
...								
	Дүн							

Засгийн газрын 2004 оны 88 дугаар тогтоолын 2 дугаар хэсрэлт

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЗАГВАРЫГ АШИГЛАХАД БАРИМТЛАХ ЗААВАР

1. ЗААВРЫН ЗОРИЛГО

Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөл боловсруулах нийтлэг загварын дагуу Үндсэн чиглэлийн төслийг боловсруулахад энэхүү зааврыг баримтлах бөгөөд энэхүү заавар нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудаас боловсруулж ирүүлсэн Үндсэн чиглэлийн төслийг хянан, хүлээж авах үндэслэл болно.

2. ЗАГВАРЫН НИЙТЛЭГ ТЭМДЭГЛЭГЭЭ

Загварт нийтлэг ашиглагдсан тэмдэглэгээ-нүүдийг дараахь байдлаар ойлгоно: Үүнд:

-“20... оны гүйцэтгэл” гэдэгт Үндсэн чиглэлийн төсөл боловсруулж байгаа тухайн оны өмнөх оныг ойлгоно. Тухайлбал Эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төслийг 2004 онд боловсруулах ба боловсруулж байгаа жил нь 2004 он, түүний өмнөх жил нь 2003 он болно. Тиймээс “2003 оны гүйцэтгэл” гэж ойлгоно.

-“20... оны ХБГ” гэдэгт үндсэн чиглэлийн төсөл боловсруулж байгаа тухайн оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг ойлгоно. Эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөл боловсруулж байгаа бол “2004 оны ХБГ” гэж ойлгоно.

-20...оны Үндсэн чиглэл эсвэл 20... оны төсөл гэдэгт Үндсэн чиглэлийн төсөл боловсруулж байгаа оны дараахь он буюу Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх оныг ойлгоно.

-“20...-20...оны төсөөлөл” эсвэл “20...-20... оны хөгжлийн хандлага” гэдэгт дунд хугацааны буюу ойрын ирээдүйг ойлгоно. Энэ нь 3 жил байх

ба Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх оны дараагийн 3 жил юм.

Тухайлбал Эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төсөл боловсруулж байгаа бол тэмдэглэгээг “2006-2008 оны төсөөлөл” эсвэл “2006-2008 оны хөгжлийн хандлага” гэж үзнэ.

-“байгууллагын нэр” гэдэгт төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын нэрийг бичнэ. “Эрүүл мэндийн яам”, “Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар” гэх мэт

-“салбарын нэр” гэдэгт тухайн төрийн захиргааны төв байгууллагад харьяалагдах салбарын нэрийг бичнэ. Тухайлбал Эрүүл мэндийн яамны хувьд “Эрүүл мэндийн салбарын” гэх мэт.

3. ЗАГВАРЫН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдэгдэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдэгдэл нь салбар болон орон нутгийн хэмжээнд боловсруулсан Үндсэн чиглэлийн төслийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсан тухай мэдэгдэл юм. Энэхүү мэдэгдэлд төсвийн ерөнхийлөн захирагчийн дараа жилийн үр дүнгийн гэрээнд үндсэн чиглэлд тусгагдах бодлогын зорилт, арга хэмжээний матрицад оруулсан зорилтууд хэрхэн тусгагдахыг бичнэ. Мөн бодлогын хувьд тухайн салбар болон орон нутагт (үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх жилд) авч хэрэгжүүлэх гол зорилтыг тодорхойлж тусгана.

2. Танилцуулга

Энэ хэсэг нь аймаг, нийслэлийн эсвэл салбарын хөгжлийн байдал болон боловсруулсан

үндсэн чиглэл, дунд хугацааны хөгжлийн хандлагын талаархи мэдээллийг багтаасан байна.

2.1 дүгээр хэсэг Танилцуулгын 2.1 буюу нэгдүгээр хэсгийг бичихдээ аймаг, нийслэлийн хувьд тухайн орон нутгийн хөгжлийн байдлыг, бүс нутгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийн талаар бичнэ. Харин төрийн захиргааны төв байгууллагууд буюу яамдын хувьд өөрсдийн харьяалах салбарынхаа хөгжлийн байдлыг гаргаж бичнэ. Өнөөгийн байдлыг бичихдээ салбарын болон аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүдийн өмнөх жилүүдийн гүйцэтгэл болон тухайн оны хүлээгдэж буй гүйцэтгэлд тулгуурлан бичнэ.

Мөн энэ хэсэгт тухайн салбарт болон орон нутагт өмнөх онуудад авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ, түүний үр дүн, мөн улсын хэмжээнд авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээ нь тухайн салбарт, орон нутагт хэр үр дүнгээ өгсөн, эсвэл үр дүнгүй болсон тухай түүний шалтгааныг авч үзэж дэлгэрэнгүй дүгнэлт өгч бичнэ.

2.2 дугаар хэсэгт үндсэн чиглэлд тусгах бодлогын зорилт, арга хэмжээний матрицыг танилцуулан бичих ба ингэхдээ үндсэн чиглэлийн бодлого, арга хэмжээний матрицад тусгагдсан зорилт тус бүрийн тухайн аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжил эсвэл салбарын хөгжилд хэрхэн нөлөөлөхийг зорилтот үзүүлэлтүүдийн хүрээнд тодорхойлон бичнэ.

Мөн энэ хэсэгт дунд хугацааны зорилтыг товч тодорхойлон, түүнийг хэрэгжүүлэх арга замыг томъёолж өгнө. Дунд хугацааны бодлогын зорилтууд нь Үндэсний хөгжлийн үзэл баримтлал, хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын ядуурлыг бууруулах стратеги, дунд хугацааны бодлогын бусад баримт бичгүүдэд суурилсан байх шаардлагатай.

Тухайн салбарын болон аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдийн тайлбарыг бичихдээ зураг, диаграмм, харьцуулалт, хүснэгтээр илэрхийлэхийг эрмэлзэх хэрэгтэй.

3. Эдийн засаг, нийгмийг 20... онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах бодлогын зорилт, арга хэмжээний матриц

3.1. Бодлогын зорилт, арга хэмжээ

а/ Бодлогын зорилт гэдэг нь тухайн салбарын эсвэл бүс нутаг, орон нутгийн хүрээнд чухал ач холбогдолтойд тооцогдон, тухайн жилд хүрэхээр төлөвлөж байгаа ерөнхий үр дүн юм. Тухайн жилийн бодлогын зорилт нь Үндэсний хөгжлийн үзэл баримтлал, хөтөлбөр, Засгийн газрын

үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын ядуурлыг бууруулах стратеги, бусад батлагдсан хөтөлбөр, төсөлд байгаа бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд түлхэц болохоор байх бөгөөд хяналт хийгдэхүйц үр дүнгийн үзүүлэлтүүдийг агуулсан байх шаардлагатай. Бодлогын зорилт нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын тухайн жилийн үр дүнгийн гэрээнд тусгагдах бүтээгдэхүүнээр илэрхийлэгдэж байх чиглэлийг түлхүү барьж тодорхойлогдоно.

б/ Арга хэмжээ гэдэг нь бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд тухайн жилд хийгдэх гол ажлууд юм. Арга хэмжээ нь эрх зүйн орчин бүрдүүлэх хүрээнд хуулийн төсөл боловсруулж батлуулах, УИХ, Засгийн газрын тогтоол, бусад шийдвэр гаргаж хэрэгжүүлэх, бодлогын зорилгод нийцсэн зохион байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүдийн зорилтот хэмжээг хангах хэлбэртэй байна.

Арга хэмжээнүүдийг ач холбогдлын түвшин, хэрэгжүүлэх хугацааны дарааллаар нь эрэмбэлэн төсөв, хөрөнгө бусад эх үүсвэр, зохион байгуулалттай уялдуулан сонгож үндсэн чиглэлийн төсөлд тусгана. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээнээс Засгийн газрын хөтөлбөрт туссан онцгой ач холбогдолтойг нь салган багцалж Үндсэн чиглэлийн бодлого, арга хэмжээний матрицад тусгаж болно.

Үндсэн чиглэлд тусгах бодлогын зорилт, арга хэмжээний матрицыг боловсруулахдаа Үндсэн чиглэлийг боловсруулах, батлуулах, түүнийг хэрэгжилтийг хангахад баримтлах журмын 6 дугаарт заасан бүтэц, агуулгыг баримтална.

Бодлогын зорилт арга хэмжээний жишээ:

Бодлогын зорилт: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтын хэрэгжүүлэх хүрээнд хөдөөгийн малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.

Арга хэмжээ 1: Хямд, удаан эдэлгээтэй, найдвартай ажиллагаа бүхий нарны зайн импортыг нэмэгдүүлж, татварын хөнгөлөлт үзүүлэх замаар малчин өрхийг нарны зайн эрчим хүчээр хангана.

Арга хэмжээ 2: Малчдад нарны зай, салхин сэнс нийлүүлэх, худалдах, гэрээгээр олгох тогтолцоог бүрдүүлнэ.

Арга хэмжээ 3: Сэргээгдэх эрчим хүчний сүүлийн үеийн бусад эх үүсвэрүүдийг судлан, гадаад орнуудаас хямд нийлүүлэх боломжийг судалж шийдвэрлэнэ.

3.2. Үндэслэл тайлбар

Энэ хэсэгт тухайн арга хэмжээ тус бүрийг яагаад бодлогын матрицад оруулах болсон шалтгааныг бичнэ. Ер нь бодлогын арга хэмжээ бүр нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бусад батлагдсан төсөл хөтөлбөрт тусгагдсан байх шаардлагатай. Үндэслэл тайлбар хэсэгт яг ямар төсөл, хөтөлбөрт тусгагдсан тодорхой бичих ба хэрэв батлагдсан төсөл, хөтөлбөрт тусгагдаагүй зорилт арга хэмжээг оруулж байгаа бол зайлшгүй оруулах болсон шалтгааныг бичнэ.

3.3. Зардал

а/ Эх үүсвэр. Арга хэмжээнүүдийн хөрөнгийн эх үүсвэр төсвийн хүрээний мэдэгдэл, гадаадын зээл, тусламж, бусад эх үүсвэрээр баталгаажсан байх шаардлагатай ба арга хэмжээний эх үүсвэр гэсэн баганад эдгээрийн алинаар нь санхүүжигдэхийг доорхи ангиллын дагуу тодорхой бичиж өгнө:

- төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдан санхүүжигдэх
- гадаадын хөнгөлөлттэй зээлээр санхүүжигдэх
- гадаадын буцалтгүй тусламжаар санхүүжих
- тусгайлан зардал шаардагдахгүй үйл ажиллагааны зардлаар санхүүжигдэх

б/ Зардлын хэмжээ. Төлөвлөсөн зардлын мөнгөн дүнг тавьж өгнө.

3.4. Арга хэмжээг хэрэгжүүлээд хүрэх үр дүн

Арга хэмжээг хэрэгжүүлээд гарах үр дүн хэсэгт тухайн арга хэмжээний эцсийн үр дүнг тодорхой үр дүнгийн үзүүлэлтээр тайлбарлах эсвэл батлагдсан төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үзүүлэх ач холбогдлыг нь гаргаж харуулна.

4. Хөрөнгө, санхүүгийн хувьд хүндрэлтэй байгаагаас тасарч болзошгүй арга хэмжээний жагсаалт

Энэ хүснэгтэд шийдвэрлэх шаардлагатай боловч зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн

боломжгүй байдлаас болоод хугацаа хоцорч байгаа, цаашид шийдвэрлэгдэхгүй байх магадлал бүхий арга хэмжээг хамруулна. Ач холбогдол, хэрэгжүүлэх хугацааны хувьд эрэмбэлээд төсөв, хөрөнгийн боломжид тохирсон эн тэргүүний арга хэмжээнүүдийг үндсэн чиглэлд оруулах бодлогын матрицад тусгах ба хөрөнгө санхүүгийн хувьд хүндрэлтэй байгаагаас тасарч болзошгүй арга хэмжээний хүснэгтэд тусгагдах арга хэмжээнүүд нь тухайн жилд хэрэгжүүлэх шаардлага байгаа ч төсөв, хөрөнгө оруулалтын боломжгүйгээс үлдэж байгаа арга хэмжээнүүд байна. Өөрөөр хэлбэл бодлогын матрицад туссанаас ач холбогдлын хувьд илүү биш ч тухайн жилд хэрэгжүүлэх шаардлага байгаа арга хэмжээнүүд болно. Эдгээр арга хэмжээнүүд нь гадаад эх үүсвэр шийдвэрлэгдэхгүй байгаагаас хойшлох магадлал өндөр арга хэмжээнүүд байна.

Тасарч болзошгүй арга хэмжээнүүдийг ач холбогдол, хугацааны хувьд эрэмбэлэн, төсөл, хөтөлбөрт туссан байдал, шаардагдах хөрөнгийн хэмжээ, хэрэгжүүлсэн байх хугацааг нь тодорхой бичнэ.

5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээ

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих арга хэмжээний хүснэгтийг бөгөлдөө санхүүжилтийг сая төгрөгөөр тавих ба хөрөнгө оруулалтын 20...төсөл, дунд хугацааны төсвөлүүдийн төсөвт өртгийн дүн, төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд тухайн ерөнхийлөн захирагчид өгсөн хөрөнгө оруулалтын хязгаараас ихгүй байна.

Хөрөнгө оруулалтын өгөгдсөн хязгаарт өмнөх жилүүдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилтийг хуваарийн дагуу оруулж тооцон, хөрөнгө оруулалтын арга хэмжээ нэмж хэрэгжүүлэх боломж үлдэж байвал Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад батлагдсан төсөл, хөтөлбөрт суусан арга хэмжээг нэмж оруулна.

Төсөл, арга хэмжээний үр дүнгийн үзүүлэлт хэсэгт тухайн объектын хүчин чадлыг харуулах үзүүлэлтийг тавина. Тухайлбал, эмнэлгийн барилга бол орны тоо, сургуулийн барилга бол сурагчийн суудлын тоо гэх мэт.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 2.5